



СОЁЛ ХООРОНДЫН ИДЭВХТЭЙ ХАРИЛЦААНЫ НӨХЦӨЛ ДЭХ ЯРИАНЫ СОЁЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДЛАХ АРГАЗҮЙН АСУУДАЛД

СУИС - ийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор Ж.Долгорсүрэн

Abstract

We can say that spoken language culture is abilities of people, who are creators and bearers of culture in a way of expressing and implementing the world signs, created inside human spirit, understandably or expressively with the result of the speech functions, and in a way of forming it with the use of language signs.

Now it is getting more important to study the spoken language culture, which has been often studied from the point of view of linguistics only, as a creative work expressing extraordinarily well the human nature and national mentality from the point of view of culture studies, linguoculturology, and cultural anthropology.

Therefore, through my article, I tried to say how to understand the spoken language culture, and in which framework other scientists consider it in their researches.

1. Ярианы соёлын хувьсал өөрчлөлтийн үндэс

Ярианы соёлын тухай Үгээр баялаг, утга гүн, найруулга яруу, хэмнэл цэгц, аялга сонсголонтой, энгийн бөгөөд ойлгомжтой сайхан өгүүлэх эрдмийг эзэмших нь ярианы соёлын гол үзүүлэлт мөн. Техник, технологийн үсрэнгүй хөгжил, даяаршлын хурдтай үйл явцын үр дүнд соёл хоорондын харилцаа /межкультурная коммуникация/ идэвхжиж, олон соёл харилцан хил хязгааргүй нэвтрэлцэж, үндэсний соёл өөр хоорондоо уусан нэвчих /аккультурация/, ижилсэх үйл явц идэвхжиж болсон нь аман соёлоор, түүний дотор ярианы соёлын хувьсал өөрчлөлтийн хүрээнд мэдэгдэм анзаарагдах болов. Иймд соёл хоорондын идэвхтэй харилцааны явцад өөрийн үндэсний болон бусад үндэстний соёлын хувьсал өөрчлөлт, өвөрмөц шинж чанарыг танин мэдэх арга замын нэг нь амьд хэл болох ярианы соёлыг хүн төвтэй шинжлэх ухаануудын уулзвар заагт тавьж судлах явдал юм.

Хэл ярианы соёлын асуудлыг зөвхөн хэлний хөгжлийн талаар судалгаа хийсэн цөөн хүний үнэлэлтэд тулгуурлан шийдэж хэрхэвч болохгүй (Ожегов. 1974.287) гэж Оросын хэл шинжлэлийн нэрт эрдэмтэн С. И. Ожегов нэгэнтээ тэмдэглэсэн нь уг асуудлыг тал бүрээс нь судлан шинжлэх шаардлагатай гэсэн үг хэмээн ойлгож байна. Үүнд хэлний хүн судлал, соёлын хүн судлал, хэлний соёл судлалын гүйцэтгэх үүрэг их юм. Ялангуяа амьд хэл, ярианы соёлын хөгжил, хувьсал өөрчлөлтийн асуудлыг тухайн соёлыг бүтээн тээгч хүмүүнээс нь үүдэж судлан шинжлэх явдал бол хэлэх, ярих үйлэндээ илэрч буй хүний мөн чанарыг танин барих ихээхэн ач холбогдотой билээ. Хүний мөн чанарын талаар нухацтай судалгаа хийхийг оролдсон хэн ч гэсэн “хүн бол хамгийн хэцүү, нууцлаг, үл ойлгогдох зүйл” (Тейяр-де-Шарден. 1987.135) гэдгийг хүлээн зөвшөөрөх буй заа. Гэхдээ хүний тэрхүү нууцлаг, ойлгоход хэцүү бэрх мөн чанар нь амьд хэл яриандаа хамгийн хүрц тод илэрч байдаг

онцлогийг харгалзан үзэж бид аман соёл, тэр дундаа ярианы соёлыг соёл судлалын шинжилгээний нэг гол чиглэл болгон сонгож, уг сэдэвт анхаарлаа хандуулах болсон юм. Ярианы соёлыг соёл судлалын үүднээс холбогдох шинжлэх ухаануудын уулзвар заагт тавьж судлах оролдлого бол монголын хэл шинжлэл, соёл судлалын практикт нэвтэрсэн цоо шинэ хандлага юм.

Хурдтай даяаршлагдсан, мэдээлэлжсэн, хотжиж, техникжсэн өнөөгийн эринд монголын үндэсний соёл өөрийн язгуур чанараа гээж, бусдын соёлоор баянж хөгжих болсон нь цаанаа монгол хүний мөн чанарын, тэр дундаа монгол үнэлэмжийн хурдтай хувьсал өөрчлөлтийг илтгэж байдаг бөгөөд энэ нь монгол хүний хэлэх, ярих үйлд илүү тод илэрч байгааг төвөггүй анзаарч болно. Монгол хүний оюун санаа, дотоод мөн чанарын энэхүү өөрчлөлтийг ярианы соёлын хувьсалыг тандан судлах замаар танин барих бололцоотой гэж үзэж байна.

“Соёлын уламжлал хэрэгжих олон янзын арга зам байдгийн нэг нь оюун санаа-авиа-үг-хэл-хэлэхүйн цогц үйлэнд соёлын үнэт зүйл /үнэлэмж/ илрэн орших явдал юм. Үүнийг бид аман аргаар соёлын үнэт зүйл илэрч уламжлагдах арга буюу сэтгэхүй хэмнэхүйн зарчмын үүднээс аман соёл хэмээн нэрлэсэн”/Ж.Долгорсүрэн. 2000.79/ билээ. Аман соёлыг бид өмнөх судалгаандаа 1. Ерийн харилцааны аман соёлын үнэт зүйлс 2. Ёслол хүндэтгэлийн 3. Тайлга тахилгын 4. Аман зохиолын төрөл зүйл (мөн тэнд. 96) гэсэн ерөнхий ангиллыг уг соёлын гүн бүтцэд үндэслэн, соёлыг хүмүүнчлэн үзэхүйн арга зарчмын үүднээс хийсэн юм. Энэ удаагийн судалгаагаар бид хүмүүсийн ерийн харилцаан дахь аман соёлын зүйлсээс ярианы соёлыг сугалан авч, чухам ярианы соёл гэдгийг хэрхэн ойлгох, соёл судлал, хэл шинжлэл, хэлний соёл судлалын уулзвар заагт холбогдуулан түүнийг хэрхэн яаж судлах аргазүйн үндсийг боловсруулах, үүний тулд судлагдсан байдлыг нь нарийвчлан тодруулахыг зорьсон юм. Ингэхдээ урд өмнө нь зөвхөн хэл шинжлэлийн судлагдахуун мэт үзэж ойлгож ирсэн ярианы соёлыг соёлын хүн судлал, хэлний соёл судлалын чиг баримжаагаар уг соёлын үзэгдлийг бүтээн тээгч хүмүүнийх нь үнэлэмжийн ахуй /оюун санааны дээд ахуй/, оршихуйн үндэстэй нягт холбоотойгоор, бүтэц тогтолцоонд нь холбогдуулан авч үзэх боломжийг эрэлхийлэв.

Ярианы соёл хүмүүсийн өдөр тутмын харилцааны хэрэгсэл болон оршдогийн хувиар өргөн олныг хамардаг онцлогтой хэдий ч аман соёлын бусад төрөл зүйлийг бодвол харьцангуй хувь бодгалийн үнэлэмжийг түлхүү илэрхийлдэг онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, амьд хэл яриа нь өгүүлэгчийнхээ сэтгэлгээ, оюуны цар хүрээ, мэдлэг чадвар, мэдрэмж авьяас, зан араншин, хүмүүжил, ёс суртахуун зэрэг хувийн шинжийг илүү тод илэрхийлдэг. Ярианы соёлыг монгол хэлний шинжлэлд “хэл ярианы соёл” гэсэн нэрийн дор гол төлөв харилцааны хэрэгсэл, сэтгэхүйн зэвсэг болох талаас нь марксист хэл шинжлэлийн диалектик материализмын үүднээс хэл яриа чухам яагаад оршин



тогтнож байна гэдэг талаас судалж, “хэл бол санааны дамжиггүй бодит байдал”(К.Маркс), “хэл бол хүмүүсийн харилцааны хамгийн чухал хэрэглүүр” (В.И.Ленин) гэсэн сургаалиудыг нэгэн үе даган баримталжээ. Ингэхдээ тэд хэл яриа нь сэтгэхүйн зэвсэг, бодит байдлын тусгал болон оршиж байна гэж нотолж, баталж ирсэн юм. Тэгвэл орчин үеийн хэл шинжлэлд хэл яриа чухам яаж оршин тогтнож байна вэ? гэдгийг гол болгож судалгааны онол аргагүйгээ боловсруулж байна. Хэл ярианы механизм чухам яаж ажиллагдийг орчин үеийн хэл шинжлэл судлахаас гадна, бас чухам яаж уг үзэгдлийг судлах вэ? гэдгээрээ судлаачид бие биесээс ялгардаг олон зүйл үзэл онолыг боловсруулсан байна. Хэл ярианы соёл гүн гүнзгий утга чанарыг тээсэн олон талт үзэгдэл болохын хувиар түүний баримт сэлтийг судлан шинжлэх арга зүй ч мэдлэгийн салбар бүрд харилцан адилгүй байна. “Философичид хэл яриаг ямар нэг түгээмэл ухагдахууны гадаад илрэл гэж үзэж байхад, сэтгэл судлаачид хэл яриаг олон үүрэг бүхий дохио гэж ажигласан байдаг. Хэл шинжлэлч нар ч гэсэн хэл яриаг өөр өөрөөр, тухайлбал, зарим нь хэлийг бодь бие (субстанция) гэж ажиглаж байхад, зарим нь тогтолцоо (система) гэж” (Нямсүрэн.1974. 10) үзсэн байна. Ингэхдээ хэлийг бүтээн тээгч хүнээс нь ангид, ямар нэг таамгийн зүйл болгон амьдчилах, домогшуулах, нэг ёсондоо хэлийг өөрийг нь хүншүүлэн тайлбарладаг онолын хандлага байсныг тэмдэглэх хэрэгтэй. “Үүний нэг жишээ нь хэл бол зөвхөн “өөрөө өөртөө”, “өөрийгөө эрхшээх” зүйл болох тухай үзэл онол юм”(Баянсан. 2002.3). Үүний нөгөө талд хэл яриаг тээгч хүн бол хэлний тухай шинжлэх ухааны судлагдахуун болох ёстой хэмээх үзлийг баримталдаг хүмүүнлэг хэл шинжлэлийн хандлага /Linguistic anthropology/ ч бас хөгжиж ирсэн байна. Уг онолыг үндэслэгч Германы хэл шинжлэлтэн В.Фон Гумбольдт “Хэл шинжлэл нь өөртөө эцсийн зорилго агуулдаггүй, харин бусад холбогдох салбар ухаануудын хамтаар хүний оюун санааны хамтын эрмэлзлийн дээд, нийтлэг зорилгод үйлчилж, улмаар хүн өөрөө өөрийгөө танин мэдэх, хүний эргэн тойрон байж хүнд өөрт нь үзэгдэж мэдрэгдэх хийгээд бас хүнээс өөрөөс нь далд нууцлаг байдаг бүх зүйлд хэрхэн хандаж харьцах зорилгод нь үйлчилж байдаг”(мөн тэнд. 3) гэжээ. Энэ нь хэл шинжлэлийг трансцендент ахуйн тухай философи, соёл судлал, тэр дундаа соёлын хүн судлалтай зайлшгүй уялдан холбогдох шаардлагатай болохыг илтгэж байна. Тийм ч учраас хэлний соёл судлал, хэл-сэтгэл судлал, хэл-угсаатны судлал, хэл-танин мэдэхүйн онол, хэл-нийгэм судлал зэрэг хэлний үзэгдлийг холбогдох олон салбар ухааны уулзвар зааг дээр бүтээн тээгч хүмүүнээс нь үүдэж судлан шинжлэх онол аргазүйн хандлагууд үүсэн хөгжиж байна. Үүний зэрэгцээгээр хэл болон хэлэх, ярих үйлийг “бие-хэл-сэтгэл”-ийн цогц болох хүмүүний оршихуйн үндэс, сэтгэл оюуны дээд ахуйн илрэл, хэрэгжилт болох талаас судалгааг хөгжүүлэх нь хэл соёлын үнэн мөн чанарыг танин барих, хэл, яриандаа илрэх хүмүүний мөн чанарыг танин мэдэхэд дөхмийг үзүүлнэ хэмээн бид үзэж байна.

Хэл яриаг соёлоос ангид, эсвэл соёлыг хэл, ярианаас ангид судлан танин мэдэх аргагүй бөгөөд ерөөс хэл бол хүмүүний сэтгэл, оюуны чинадад боловсорсон утга санааг тээн илэрхийлэгч арга, хэрэгсэл болохын хувьд соёл мөн. Тэгээд ч хэл соёлын харилцан хамаарлын тухай асуудлын язгуур сурвалж нь нэн эртнээс улбаатай болохыг эрдэмтэд тэмдэглэсээр иржээ. В.Фон Гумбольдтын энэ талаар дэвшүүлсэн санааг сүүлийн үед дотоод, гадаадын эрдэмтэн мэргэд олонтаа ишлэх болсон нь хэлийг хүн төвт хэлшинжлэл /Anthropological linguistics/, соёлын хүн судлал/Cultural anthropology/-ын үүднээс судлах асуудал улам чухал болж

байгааг давхар илтгэж байна. Өөрөөр хэлбэл, соёлын экологи, соёлыг бүтээн тээгч хүмүүний оюунлаг (менталитет)-н мөн чанар, хувьсал өөрчлөлтийг танин мэдэхийг хүсвэл соёл судлал, соёлын хүн судлал, хэлний соёл судлал бүгд хэл ярианы соёлын асуудалд анхаарлаа хандуулах нь зүйн хэрэг болно. Иймээс ярианы соёл бол соёл судлал, соёлын хүн судлалын зангилаа асуудлын нэг гарцаагүй мөн.

Соёл судлалын үнэлэмжийн онол аргазүй, соёлыг хүмүүнчлэн үзэхүйн арга зарчмын үүднээс авч үзвэл ярианы соёлоор хүн ба нийгмийн үнэлэмж, тэдгээрийн мөн чанар тод илэрч байдаг онцлогтой юм. Иймд ярианы соёлыг үндэсний соёлын илрэн оршихуйн хамгийн идэвхитэй амьдлаг хэлбэр, бие даасан төрөл зүйл хэмээн үзэж болно. “Ярианы соёл” зөвхөн өгүүлэгчийнхээ амьд чадвар болох өгүүлэхүйн үйлийн үр дүн болон оршдог онцлогтой бөгөөд энэ нь хэлний ерөнхий хуулинд захирагдан үүссэн хэл соёлын үндсэн төрөл хэлбэрийн нэг мөн билээ. Хэл хэмээх ерөнхий бөгөөд хийсвэр ойлголтыг хэл, яриа гэж ангилсан ангилал ч эртний түүхтэй юм. “Хүний амаар хэлснийг чихээр сонсож болно. Мөн амаар хэлснийг үсгээр тэмдэглэж, нүдээр уншиж болно. Амаар хэлэхэд авиа нь хэлний дохионы тэмдэг болдог бол бичгээр бичихэд үсэг нь бичих дохионы тэмдэг болно. Энэ учраас амаар хэлэх нь анхдагч, бичгээр бичих нь хоёрдогч үзэгдэл болно” (Ш.Лувсанвандан. 1968. 3) гэжээ. Иймд хүний оюун, сэтгэлийн гүнд боловсорсон утга санааг хамгийн тод илтгэх чадвартай соёлын анхдагч хэлбэр бол аман соёл, тэр дундаа ярианы соёл мөн.

“Ярианы соёл” хэмээх нэр томьёо ихэнх тохиолдолд “хэлний соёл” хэмээх ойлголттой утга дүйдэг. (Тухайлбал, герман. - Sprachpflege, англи – culture of speech эсвэл speech culture, болгар. – езикова култура г.м.) (Скворцов. 1980. 79). Гэхдээ хэл шинжлэлд эртнээс хэл, хэлэх, бичих зэргийг ялган тайлбарлаж ирсэн бөгөөд энэ нь хэлний баримтыг амьд сэрэлд өртөх, үл өртөх талаас нь авч үзсэн хэрэг юм. Хэл шинжлэлийн эрдэмтэд “ярианы хэл”, “бичгийн хэл” гэж зааглаад, зарим нь эдгээрийг нэг юмны хоёр тал гэж үзэж байхад, зарим нь бичгийн хэл ярианы хэлнийхээ үндэс болно гэж батлах нь ч бий. Тийм ч учраас бичгийн хэлийг хэл гээд, ярьж хэлэлцэж, дуугарч дуудаж байгаагаа хар муу хэл, буруу зөрүү ярьдаг бохир зүйл гэж хэл шинжлэлийн судлагдахуунаас үлдэн хөөдөг буруу зуршил ч байдаг”(Нямсүрэн.1974. 5). Гэтэл ардын “аман яриа нь үг найруулгын алдаагүй, дохио зангаа, гар нүүрийн элдэв нэмэлт хөдөлгөөн жүжиглэлгүй, эмх цэгцтэй, товч тодорхой, уран яруу, утга төгөлдөр, хөг аялга найрсуу, заримдаг бус бүрэн өгүүлбэртэй, оноч мэргэн зүйр үг, хэлц үг элбэгтэй бөгөөд ийм яриаг сонсоход үг өгүүлбэр нь сонорт тос нэвчих мэт зөөлөн орж, сэтгэлд бахархал тайвшрал төрүүлж, ухаанд ухаан нэмж сургамж хайрладаг” (Баттогтох.2003.№3/17/). Ардын ийм яриаг академич Б.Ринчен “хар хэл”, “модон хэл” биш харин жинхэнэ монгол найруулгатай боловсон “аман-бичгийн хэл” (Ринчен. 1966) гэж нэрлэсэн байдаг. Ерөөс аливаа соёлын үр хөврөл эхлээд бүтээгч хүмүүнийхээ оюун, сэтгэлд утга санааны хэлбэрээр үүсч бүрэлдээд, улмаар үг, хэл, яриа, хэлэхүйн үйлэнд амилан биеждэг онцлогтой. Ингэж бүтсэн ярианы соёл харьцангуй хувь бодгалийн шинжтэй, амьд харилцааг бий болгодог учраас нэмэлт засвар үгүй, уран яруу байдаг.

В.Фон Гумбольдт “хэл, яриаг зааглан үзэж, амьд хэлнүүдийн талаар хийсэн судалгаандаа түшиглэн, тухайн хэлээр хэлэлцэгч хүмүүс нэг л хэлээр хэлэлцэх боловч ярилцах тухайн агшинд хүн бүхэн өөр өөрийн хэл яриатай байдаг гэсэн дүгнэлт хийж, амьд ярианы хэлийг судлахад хувь хүний



хэл яриаг судлах нь зайлшгүй хэрэгтэй зүйл” (Березин. 1975. 50) хэмээн тэмдэглэжээ. Хүн төрөлхтөн бичигтэй болоод төдий л удаагүй. Гэтэл хэлдэг ярьдаг болоод хэдүй их удсаныг бид сайн мэдэх билээ. Одоогоос зуугаад жилийн өмнө бичиг үсэг мэдэх явдал зөвхөн язгууртан дээдсийн хэрэг байсан бөгөөд олон сая энгийн хүмүүс бичиг уншиж чаддаггүй байв. Харин тэр үед хөгжиж боловсроогүй хэлтэй тийм овог, ястан үндэстэн нэгээхэн ч үгүй байв. Иймд үндэсний соёлын онцлог хийгээд тэдгээрийн хувьсал өөрчлөлтийг танин мэдэхийг хүсвэл соёлын хамгийн түгээмэл хэлбэр болох аман ярианы соёлыг судлах нь зайлшгүй чухал болно. В.Фон Гумбольдт “хэл яриа бол санаа бүтээгч эрхтэн болой. Дотор ертөнцийн нүднээ үл үзэгдэх гүн гүнзгий оюуны үйл ажиллагаа нь хэлний авиагаар дамжин боджиг сэрэлд өртмүй. Чухам үүний учир сэтгэхүйн үйл ажиллагаа хэл хоёр салшгүй нэгдэлд оршмой” гэж баталж байв. Үүний зэрэгцээгээр “хэл нь санааны авиажсан илрэл. Хэл бол авианд илэрч гардаг санаж сэтгэхийн процесс” (А.Шлейхар), “хэл бол санааны хэлбэр” (Л.Потевня) гэж үзсэн байхад, зарим нь, тухайлбал орчин үеийн бүтэц хэл шинжлэлийн гол онолыг үндэслэгч, Швейцарийн нэрт хэл шинжлэлч Фердинанд үе Соссюр “хэл, яриа хоёрыг хэлний бодит байдал нэгтгэж байдаг бөгөөд гол ялгаа нь хэл бол нийгмийн шинжтэй, яриа хувийн шинжтэй байдгаар тодорхойлогдоно” (Березин. 1975. 1,185) гэжээ. Ингэж үе үеийн судлаач эрдэмтэд хэл, ярианы холбоо хэлхээ болон зааг ялгааг тал бүрээс нь тодруулахыг оролдсоор иржээ.

Эд бүгдэд үндэслэн “хэл ярианы” гэсэн тодотголыг хэрэглэхгүй, “ярианы соёл” гэсэн товч тодорхой нэрээр нь уг соёлын зүйлийг нэрлэж занших саналыг дэвшүүлж байна. **Ярианы соёл бол хүний сэтгэл оюуны дотоод далд ухамсар дахь үнэлэмжийн гүн бүтэц, түүнийг тээн илэрхийлэгч үг, хэл, өгүүлэхүйн үйлийн хэм хэмжээг сахих ухамсрын өнгөн бүтэц бүхий хоёр талт нэгдмэл тогтолцоо мөн.**

Семиотикийн онолчид соёлыг дохио тэмдгийн тогтолцоо хэмээн үзсэн байх бөгөөд энэхүү тогтолцооны нэг бүрэлдвэр хэсэг бол хэлний дохио тэмдгийн тогтолцоо мөн. Хэлийг дохионы систем гэж үзсэн санал эртний Энэтхэгт ч мөн байсныг “Энэтхэгээс уламжлалтай хуучны хэл шинжлэлд түвэд-монгол үгийн толь бичгийг түвэд-монгол дохионы бичиг гэж нэрлэж байсан” (Лувсанвандан. 1977. 55)-аас тодорхой харж болно. Академич Ш.Лувсанвандан хэлийг гүн бүтэц, өнгөн бүтэц бүхий дохионы систем гэж үзсэн. Үнэхээр соёлын ямар ч үзэгдэл өөрийн гэсэн өвөрмөц тогтолцоо бүхий нарийн нийлмэл систем гэдгийг бүтэц үүргийн шинжилгээний онолыг үндэслэгч Claude Levi Strauss /Клод Леви-Строс/ зэрэг структурализмын төлөөлөгчид баталж нотолсон байдаг. Энэ онолын хандлага ёсоор ярианы соёлыг авч үзвэл өгүүлэгч этгээд сэтгэл, оюундаа ертөнцийг өөрийнхөөрөө тусгасан дохио нь ярианы соёлын дотоод гүн бүтцийг бүрдүүлж байна. Энэ нь хэлний дохионы анхдагч систем бөгөөд соёлын хүмүүн ертөнцийн юмс, үзэгдлийг ямарч болзолгүй шууд мэдрэх үйл явц юм. Хүний мэдрэх боломж хязгаартай тул хязгааргүй ертөнцийн юм, үзэгдлийг хэсэг хэсгээр нь хязгаарлан мэдрсэн дохионыхоо анхдагч системийг мөн хэсэг хэсгээр бие биеээс нь хязгаарлан, хэлний дохионы хоёрдогч системд буулгадаг. Дохионы энэхүү хоёрдогч систем нь хүний хэл яриа бөгөөд энэ нь ярианы соёлын ухамсарт үйлийн үр дүн болох өнгөн бүтцийг бүрдүүлж байна. “Дохионы анхдагч системд хамаарах юм, үзэгдлийн бүтэц нь байгалийн ерөнхий жамаар, байгалиасаа дам шүтэн барилдаж бүтдэг бол, дохионы

хоёрдогч системд хамаарах хэлний дохионы янз бүрийн нэгж-морфем, үг, холбоо үг, үгэлбэр, энгийн морфем нь фонемоос, үг нь морфемоос, холбоо үг нь үгнээс, үгэлбэр нь холбоо үгнээс дам дам шүтэн барилдаж бүтсэн байна” (Лувсанвандан. 1977. 55). Ярианы соёлын дохионы анхдагч системд багтах байгалийн юмс, үзэгдэл байгалийнхаа зүй тогтолоор хөгжихийн явцад бүтэж, эвдэрч байдаг бол, дохионы хоёрдогч системд багтах хэл, ярианы дохионы янз бүрийн нэгж нь хүний нийгмийн хөгжлийн явцад мөн бүтэж, эвдэрсээр ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эвдрэхгүй бүтэх, бүтэхгүй эвдрэх юм, үзэгдэл гэж ерөөс байхгүй, ямагт бүтэхийн хамт эвдэрч, эвдрэхийн хамт бүтэж байна гэсэн үг. Ярианы соёлын гүн бүтэц /дохионы анхдагч систем/ нь утга санаа буюу агуулгыг, өнгөн бүтэц /дохионы хоёрдогч систем/ нь хэлбэрийг тус тус бүрдүүлж байна. Дохионы анхдагч систем /агуулга/-гүйгээр дохионы хоёрдогч систем /хэлбэр/ гэж байж болохгүй. Харин дохионы хоёрдогч систем /хэлбэр/-гүйгээр дохионы анхдагч систем /агуулга буюу утга санаа, үнэлэмж/ гэж байна. Эндээс ярианы соёлын дохионы систем ертөнцийн түм буман юм, үзэгдэл, тэдгээрийн хөдөлгөөнтэй шүтэн барилдаж үүсэн хөгжсөн хийгээд тэдгээрээс шалтгаацаж оршин тогтнодог болохыг анзаарч болно. Ийнхүү **ярианы соёлыг бүтэц тогтолцооных нь үүднээс гүн бүтэц бүхий үнэлэмж дэх утга санаа /агуулга/, өнгөн бүтэц буюу үнэлэмжид өртөгдөн боловсорсон үзэгдэл юмс /хэлбэр/-ын харилцан шүтэлцээт тогтолцоо мөн гэж үзэж болно.** Энэхүү соёлын тогтолцоо хүмүүний хэлэх ярих амьд чадварт дулдуйдан оршихдоо бүтээн тээгч хүмүүнийхээ үнэлэмжийг илэрхийлж, оршихуйн үндсийг хангах үүрэг гүйцэтгэдэг.

Ярианы соёлыг зарим эрдэмтэн судлаач хэрэглээний үүднээс тодорхойлох оролдлого хийсэн байна. Тухайлбал, оросын хэл шинжлэлтэн Г.О.Винокур /1896-1947/ “**зөв бөгөөд чадварлаг хэл гэж үзсэн**” (Основы культуры речи, 1984, 33) бол доктор Э.Пүрэвжав **нэгдүгээрт, зөв ярьж, бичих чадвар, хоёрдугаарт, хэлний хэрэглүүрийг хүмүүсийн харилцааны янз бүрийн нөхцөл байдалд уг ярианыхаа зорилго, агуулгад зохицуулан ашиглах чадвар, дадал, эв дүй...**” (Пүрэвжав. 1993. 4) гэжээ. Эдгээр судлаачид уг соёлын үзэгдлийн өнгөн бүтэц буюу ярианы соёлоор үнэлэмж илрэн орших талд голдуу анхаарлаа хандуулсан болох нь төвөггүй анзаарагдаж байна.

Ярианы соёл байгалийн хийгээд нийгэм-түүхийн хос эх сурвалжтай үзэгдэл болохын хувиар байгаль, нийгэм, түүхийн хүчин зүйлсээс шалтгаацаж уламжлагдан шинэчлэгдэх, хувьсан өөрчлөгдөх түгээмэл зүй тогтолтой аж. Ярианы соёл өөрийн хөгжлийн жам ёсоор хувьсан өөрчлөгдөх, бас нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллөөр хөгжил нь дэвжих бас гажих доголдох тохиолдол цөөнгүй байна. Ярианы соёлын доголдолыг эрдэмтэд гол төлөв нэр томьёо, үг хэллэгийг оновчгүй буруу сонгож хэрэглэх, харь гаралтай үгийг хэрэглэмгүй газар хэрэглэх, этгээд бүдүүлэг үг хэлэх зэрэг хэлний хэм хэмжээг зөрчсөн тохиолдлуудтай холбон авч үздэг. Хэл ярианы хэм хэмжээг зөрчиж гажуудуулбал хэлж ярьсан зүйл ойлгомжгүй, буруу хазгай болохын гол шалтгаан болдог. Ярианы соёл өгүүлэгчийнхээ сэтгэлгээний онцлог, үндэс угсаа, ёс заншил, зан суртахуун, хүмүүжил төлөвшил, мэдлэг боловсролын ерөнхий төвшинг илтгэн харуулах гол хэмжүүр байсаар ирсэн бөгөөд нийгэм, түүхийн хувьсал өөрчлөлтийг хамгийн тод тусган илэрхийлдэг онцлогоороо бусад соёлын төрөл зүйлээс ялгаатай юм. Швейцарын хэл шинжлэлтэн Ш.Балли /1865-1947/ “яриа бол эхний ээлжинд нийгмийн үзэгдэл бөгөөд яригч хүнийг тодорхойлж өгдөг” (Балли.1961.27) гэж ярианы соёлын зөвхөн нийгмийн талыг



гол болгоод байгалийн эх сурвалж, байгалийн шинжийг огоорсон тал ажиглагддаг. Ерөөс “хүний хэлийг нийгмийн, бас байгалийн гаралтай”(Лувсанвандан. 1977.60) үзэгдэл гэж үзвэл ярианы соёлын байгалийн гарал бүхий уг чанарыг нь бас эн чацуу авч үзэх шаардлагатай юм. Хэл яриаг хүний ухамсар, зан үйлээс хараат оршдог зүйл гэж үзэх ёс байна. Гэхдээ ярианы соёлыг зөвхөн ухамсраар бүтээгддэг зүйл гэж үзвэл буруу ташаа болно. Учир нь хэл яриа үүсэх, хувьсан өөрчлөгдөх тохиолдол бүхэн тухайн хүмүүнийхээ далд ухамсрын /үл ухамсарлахуйн/ чинад дахь үнэлэмжийн хувьсал өөрчлөлтийг маш тод илтгэж байдаг онцлогтой юм.

Хэл яриа оршин тогтнохдоо хамгийн бага хүч зарцуулах буюу хэмнэлтийн зарчимд суурилан оршдог онцлог ч мөн далд ухамсарт үйлийн үр дүн мөн. Энэ нь соёлын нэн өргөн дэлгэр, гүн гүнзгий утга санаа товч тодорхой дохио тэмдэгт хураангуйлагдан оршдог онцлогийг илтгэдэг. Тийм ч учраас соёлын гүн утга чанарыг тайлан тайлбарлах зорилгоор семиотекийн онол, арга зүй үүсч хөгжсөн байна. Өгүүлэгч нь аль болох бага хүч зарцуулж санасан бодсоноо товч тодорхой илэрхийлэхийг чармайх, сонсогч нь аль болох бага хүч зарцуулж түүнийг нь бага цагт бүрэн ойлгох гэсэн хүмүүсийн нийтлэг зан үйлийн үр дүнд зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, зүйрлэл, адилтгал зэрэг аман соёлын олон төрөл зүйл үүсч хөгжжээ. Ялангуяа орчин үеийн хүний соёл сэтгэлгээний хурдтай хөгжил шинжлэх ухаан, техник, технологийн дэвшил хэлний дохио тэмдэгт ихээхэн хураангуйлагдан кодлогдох болсон нь нэг талаас хүмүүс хоорондын амьд аман ярианы хэлийг ихээхэн хэмнэх шаардлагыг буй болгож байгааг бид анзаарахгүй өнгөрч болохгүй. Энэ нь нэг талаас цаг хугацаа, хүч хэмнэх сайн талтай боловч, нөгөө талаасаа үг яриа хэдий чинээ товчлогдоно, төдий чинээ сэтгэл нээлттэй байх боломж хомсдох сул талтай. Энэ байдал удаан үргэлжилбэл яван явсаар амьд хэл яриа устах, улмаар хүмүүсийн чин сэтгэлийг илэрхийлсэн нээлттэй халуун дулаан харилцаа хумигдах нигууртай юм. Иймд ярианы соёлын хувьсал өөрчлөлтийг түүний байгалийн эх сурвалж болох хүний байгаль чанар (человеческая природа), үнэлэмжийн хувьсал өөрчлөлттэй, мөн нийгмийн чанар болох техник, технологийн шинэчлэлтэй зайлшгүй холбон авч үзэх нь хэлний соёл судлал, соёл хоорондын харилцаа судлалын гол зорилго юм. Хэл, сэтгэхүй хоёр нягт холбоотой байдаг учраас өгүүлэгчийн сэтгэхүйн гүнд явагдаж буй хувьсал өөрчлөлт яриагаар тод илэрч байдаг. Яриа нь хүмүүсийн оюун санааны толь болж, яригч өгүүлэгч хэл яриагаараа өөрийнхөө хэн болохыг харуулаад зогсохгүй, оюун ухаан, мэдлэг чадварын цар хүрээ, ёс суртахууны хэм хэмжээ, сэтгэхүйнхээ чадал тэнхээг таниулдаг. Амьдрал практикаар шалгагдаж нотлогдсон энэ туршлагад үндэслэж <<дөнгөн данган яригч бол дөнгөн данган сэтгэгч мөн>> гэсэн сургамжтай үг гарчээ.

Ярианы соёлын хөгжлийн төвшин хүнтэй уулзаад зүй зохистой мэндэлж хүндлэхээс эхлээд санасан бодсоноо цэгцтэй оновчтой илэрхийлж буй чадвараар юун түрүүн илэрч байдаг. Үүнд: нэг талаас, хүн ертөнцийг өөрийн төрөлх чанараар хүлээн авч боловсруулах сэтгэхүйн чадвар, сэтгэлгээ, үнэлэмж., нөгөө талаас бага наснаас хүн болж төлөвших явдаа олж авсан мэдлэг, туршлага, дадал зуршил, хэлний боловсрол зэрэг нь гол үүрэгтэй. Ярьж байгаа хүний сэтгэлгээ, сэтгэхүйн үр чадвар нь гүн угшилтай, түүний төрөлхийн заяамал шинжийг, харин түүний хэлний боловсрол нь нийгмээс олж авсан дадал туршлага, мэдлэг чадвар, мэргэжлийн онцлог, нийгэмд эзэлсэн байр суурийг тус тус илтгэдэг хоёр талтай юм. Ертөнцийг тусгах мэдрэмж, сэтгэх чадвар сул, сэтгэлгээ дорой бол ярих

чадвар муу байна. Харин сэтгэлгээ, сэтгэх чадварын хувьд хэвийн атал ярих чадвар муу байх нь хэлний боловсрол, ярих туршлагатай холбоотой байж болно. Үүнийг ялангуяа жүжигчний мэргэжил эзэмшиж байгаа оюутнууд **“Тайзны яриа”** хичээлд суралцаад үгийг хурц тод хэлж, утга санааг бүрэн илэрхийлэх үр чадвар эзэмшиж байгаа үр дүнгээс тодорхой харж болдог. Мөн **“Илтгэх урлаг”** хичээл сургалтын үр дүн ч үүнийг харуулдаг. Энэ бүхэн бол хэлний боловсрол олгох нийгмийн тодорхой аргуудын нэг мөн. Хэлний боловсролыг “аливаа хэлний утга санаа илэрхийлэх арга хэрэглүүрийг хамгийн зохистой ашиглах үйл ажиллагаа, онолын эрэл хайлтын нарийн цогц асуудал”(Барайшир. 1973. а, 47) гэж үздэг. Хэлний боловсролын түвшингээр ярианы соёлын түвшин тодорхойлогддог. Ярианы соёлын түвшингээр ч мөн адил хэлний боловсролын түвшин тодорхойлогдоно. Иймээс хэлний боловсролыг хүн бүрт багаас нь эзэмшүүлэх явдал түүхэн цаг үе болгонд чухлаар тавигдсаар ирсэн юм. Монголчууд хүүхдийг хэлд орохоос нь эхлэн зөв хэл яриаг сургахад гойд анхаарч энэ талын баялаг туршлага хуримтлуулсан ард түмэн билээ.

Нийгэм, түүхийн өөрчлөлт, шинэчлэл нь ярианы соёлын нийгмийн үүргийг улам бүр нэмэгдүүлсээр ирсэн. Өнөөдөр ялангуяа тайз, дэлгэцээс ярих урлаг нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байна. Телевиз, радиогийн нэвтрүүлэгчид өнөөгийн монголын нийгмийн ярианы соёлын гажуудлыг тэргүүлж байгааг бид өдөр бүр харж, сэтгэл зовж байдаг. Нийгмийн амьдралын олон талтай холбоотой ярианы соёл тухайн нийгмийнхээ үнэлэмж баримтлал, хөгжил дэвшил, гажуудал, доройтлыг хамгийн хурц тод илэрхийлж байдаг. Тийм ч учраас ярианы соёлын асуудал монгол хэл судлаачдын зэрэгцээгээр соёл судлаач, нийгэм-соёлын хүн судлаач, хэлний соёл судлаач, тайз дэлгэцээс ярих урлаг судлал, утга зохиол судлал, соёл хоорондын харилцаа судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Энэ чиглэлийн эрдэмтэн, судлаач, багш нар хамтран судалгаа хийх, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах зэрэг нилээд ажлыг хийж байгаа бөгөөд энэ бүхэн нь ярианы соёлыг зөв хэм хэмжээний хүрээнд хөгжүүлэхэд чиглэж байна.

Эд бүгдэд үндэслэн соёлыг бүтээн тээгч хүмүүний оюун санааны дотоод ертөнцөд бүтээн туурвисан утга санаа болох ертөнцийн дохиог хэлний дохио тэмдгээр биежүүлэн, өгүүлэхүйн үйлийн үр дүнд уран яруу, ойлгомжтой сайхнаар илэрхийлэн, хэрэгжүүлэх чадварыг ярианы соёл хэмээн ойлгож болно.

Ярианы соёлыг судалсан байдал Монголчуудын эх хэлээ судалсан үлэмж өвийн дотор ярианы соёлыг хэл шинжлэлийн ухааны нэг салбар болгон судалж хөгжүүлсэн нь харьцангуй эрт үеэс үүсэлтэй юм. Уламжлалт хэлзүйн бичгүүдэд сонгодог монгол бичгийн хэлний зөв бичих, зөв дуудах ёсны талаар олонтаа өгүүлснийг ярианы соёлын тухай асуудлыг эртнээс судалсны гэрч гэж үздэг. Алшаагийн равхамба Данзандагвын 1723-1735 оны хооронд бичсэн “Зүрхний толтын тайлбар, Үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань” хэмээх хэл зүйн бичигт номын үг лүгээ хар үг хольсон олон байгаа хийгээд, бичгийн болон ярианы үг хэллэгийг нэг дор хольж хэрэглэх нь монгол хэлний хэм хэмжээнд үл тохирохыг шүүмжилжилсний зэрэгцээ ерөөс ярианы соёл, бичгийн соёл хоорондоо зөрчилтэй хийгээд ялгаатай оршдог мөн чанарыг нээн харуулахыг оролдсон байна. Монгол үгийн бичлэг, дуудлага хоёр зөрөөтэй болсон үзэгдлийг Агваандандар /1758-1838/ олж ажиглаад “ийн бичээд тийн үнших ёс” хэмээн нэрийдсэн. Мөн “монгол бичгийн хэлэнд нэгэн адил бичээд



ярих хэлэлцэхдээ нутаг нутгийн аман аялгуугаар хэлэлцдэг ёс байдаг” (Ш.Лувсанвандан.1961,91)-ийг академич Ш. Лувсанвандан/1910-1983/ “Орчин цагийн монгол хэл” хэмээх бүтээлдээ тэмдэглэсэн байна. Монгол хэл, ярианы соёлын талаар доктор С. Галсан /1800-1870/ “Монгол үсгийн бүгд тайлбар толь”/1835/ бүтээлдээ сонгодог монгол бичгийн хэлний үгийн бичлэгийн ёс горим, монгол хэлний зүй, зөв дуудах ёсны хэм хэмжээний талаар зарим ажиглалтууд хийж, үгийн утга найруулгыг сайтар бодож онож зөв хэрэглэхийн чухлыг судлан тогтоожээ.

Финляндын нэрт монголч эрдэмтэн Г.И. Рамстедт /1873-1956/ ч бас монгол бичгийн хэлний хэм хэмжээ зөв бичихгүйг судалж, “Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора” /СПб., 1908.66/ бүтээлдээ монгол бичгийн хэлний зөв бичих ёсыг баримтлахын чухлыг тэмдэглээд (Рамстедт, 1908, 58) “тухайн үгийн утга ялгах зорилгоор монгол бичгийн хэлэнд давхарласан урт гийгүүлэгч үүссэн үзэгдлийг монгол хэл зүйн бичигт “монгол үсгийн ёсон бус боловч цаг тооны бичигт алдаршсан” (МХШДБ, 1983. 28) явдал гэж тайлбарлажээ.

“Энэ зууны гучаад оноос эхлэн орчин цагийн хэл шинжлэлийн иш үндэслэлтэй монгол хэл, ярианы соёлын талаарх судалгаа эхэлсэн”(Пүрэвжав,1996.9) гэж үздэг. Ярианы соёлын судлалд томоохон байр суурийг эзэлдэг бүтээл нь “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл”/МХБСБӨ/ нэрт есөн цуврал эрдэм шинжилгээний бичиг юм. Энэ цувралд Ц.Дамдинсүрэн/1908-1986/ “Хичээл билгээн гаргаж, хэл бичгээн хөгжүүлэе”, Б. Ринчен/1905-1977/ “Монгол хэл бичгийг эвдэн гутаах лугаа тэмцэн тулах цаг ирсэн биш үү”, “Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай”, Ч.Бат-Очир /1873-1935/ “Монгол үсгийн мөрдөн дууриах эх” зэрэг монгол хэл бичиг, ярианы соёлын амин чухал асуудлыг хөндсөн онол, практикийн ач холбогдолтой бүтээлүүд хэвлэгдэн гарч өргөн олны хүртээл болсон байна.

Академич Ц.Дамдинсүрэн “Хичээл билгээн гаргаж, хэл бичгээн хөгжүүлэе” /1934/ эрдэм шинжилгээний томоохон өгүүлэлдээ тухайн үед олны анхаарлыг ихэд татаж байсан “Хуучин бичгийг ямраар үзэх”, “Зөв бичих нь”, “Хэл бичгийн найруулга”, “Гадаадын үгийг хэрэглэх нь”, “Ерөнхий боловсрол”, “Хэл бичгийг хөгжүүлэх замууд” зэрэг сэдвийн хүрээнд ярианы соёлын тулгамдсан асуудлуудыг ямар нэг байдлаар хөндсөн байна. Тэрээр “Хэл мэдэхгүй хүн орчуулаад, үг мэдэхгүй хүн зохиогоод, үсэг мэдэхгүй хүн бичээд, үүгээр бичгийн хэргийг гүйцэтгэнэ хэмээвээс олигтой хөгжлийг олж чадахад бэрхтэй” (Дамдинсүрэн.1934.30) хэмээн цохон тэмдэглэсэн нь одоо ч үнэ цэнээ алдаагүй сургамжтай хэвээр байна.

Академич Б.Ринчен 1934 онд В.И.Лениний туурвисан “Орос хэлийг цэвэрлэн ариутгах тухай” өгүүллийг дохио санамж болгох зорилгоор монгол хэлнээ орчуулж, “Хэлийг эвдэн гутаах лугаа тэмцэн тулах цаг ирсэн биш үү” гэсэн оршил бичиж, улс гэрийн соёлыг хөгжүүлэн өрнүүлэхэд хэлнээс эрхэм нь үгүй. Гэтэл манай зарим бичиг зохиолын үг үсэг ойрноос баахан цалгай болж, эвдрэн буй мэт. Үг үсгийг хэдий үзэвч, утга санааг тутам олж ухахуйд бэрхшээлтэй газар цөөхөнгүй үзэгдэнэ. Иймд хүрсний шалтгаан нөхцлийг мохоон байцааваас түүний их төлөв нь гадаадын үгийг хэрэглэмгүй газар дэмий л зарж, утгыг балар битүүлж болгох нэгэн зүйл, Аливаа бичиг харыг монголчлон орчуулахад гадаад улсын үгний нарийн утга санааг мөчид дутуу ухах, монгол үгний дүрэм найруулал, зүй хэмжээнд нийлүүлэн буулгаж чадахгүй хоёр зүйл, Монгол зохиолд энэ хоёр ослыг

мөрдөн дууриаж, бахдан дагалдсанаар бичиг зохиолын утгыг будлиан, санааг балар болгох гурван зүйлийн үндсэн гэм” (Ринчен, 1934, а, 60) байгааг сануулсан байна. Тэрээр эл оршил өгүүллийнхээ үргэлжлэл болгон “Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай” /1934/ нэртэй монгол орчуулгын онол, зарчмыг ул суурьтай боловсруулсан эрдэм шинжилгээний бүтээлийг “Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” цувралын гутгаар дэвтэрт нийтлүүлжээ. Энэ бүтээлийг орчуулгын онолын талаарх манай хамгийн дорвитой өгүүллийн нэг гэж үздэг. Тэрээр энэ өгүүлэлдээ “орчуулах” гэдэг нэртөмьёог олон талаас нь тайлбарлаж, орчуулгад эх бичгийн агуулгыг бүрэн гаргах, цаад хэлний хэрэглүүртэй эн тэнцэхүйц хэрэглүүр олж ашиглах, монгол хэлнийхээ хэл зүйн хэм хэмжээг алдагдуулахгүй байх зэрэг үндсэн зарчмыг дэвшүүлэн гаргасан байна. Тэрээр аливаа нэртөмьёоны зүйлийг цөм нэгэн мөр болговоос, үндэсний хэлний засаг батдаж, соёл эрдэм дэлгэрэхэд тустай (Ринчен. 1934, б, 42) гэж монгол хэлний үг хэрэглээний хэм хэмжээний чухал нэгж болсон нэртөмьёог журамлах талаар тэмдэглэж байсныг одоо ч бид авч хэрэглүүштэй үнэ цэнэтэй санаа юм.

Хэл шинжлэлийн эрдэмтэн Л. Мишиг “Үгний боловсролыг эрхэмлэхийн учир” өгүүлэл бичиж, хүмүүс өөрийн хэлж гаргах гэсэн санааг бичгээр болон амаар бусдад урнаар зөв ойлгуулахын чухлыг тодорхойлж, “Үгний боловсрол нь утга уялдсан, цэвэр, тод томруун, цагаан, зөв, яруу сайхан хэлдэг, бичдэг болгохыг эрхэмлэнэ” (Мишиг, 1955, 40) гэжээ. “Хэлбэл миний дур, хийсгэвэл тэнгэрийн дур” хэмээн ярилцагч хүнээ үл ойшоон үзэж харилцах нь хэл ярианы соёлын хамгийн харш зүйл билээ. Доктор Д.Цэрэнсодном “Эх хэлээ эрхэмлэе”(1961) өгүүлэлдээ ярианы хэлний яригтай олон хэлбэрийг нэгэн мөр болгож, хоёрдмол утга гаргахаас урьдчилан сэрэмжлэхэд өгүүлбэрийн гишүүдийг зохих хэм хэмжээ, дэс дарааллын дагуу байрлуулах нь чухал хэмээн сануулсан байна. Академич Ш. Лувсанвандан /1910-1983/ монгол хэл, ярианы соёлд чухал үүрэгтэй цэрлэн нэрлэх ёсны талаарх шинжилгээ судалгааг манайд хамгийн анх удаа хийсэн хүн. Тэрээр “Эрт балар цагийн хүмүүс байгалийн элдэв үзэгдлийг шинжлэх ухааны ёсоор зөв тайлбарлаж чадах байтугай өөрсдөө байгалийн эрхшээлд ихэд автагдан байсан учир зарим догшин амьтан буюу аюулшигт үзэгдлийг шууд нэрлэхээс айн эмээж цэрлэн нэрлэх явдал” (Лувсанвандан, 1961,514) буюу үгийн цээрийг үүсгэсэн гэж үзжээ.

Монгол хэл ярианы соёлын судлалаар нэлээд сонирхолтой бүтээлүүдийг академич Б.Ринчен /1905-1977/ туурвисан байна. 1956 онд түүний бичиж нийтлүүлсэн “Хэлээ хайрлан энхрийлж, үгний боловсролыг эрхэмлэе” өгүүлэлд орчуулагч нар эх хэлнийхээ ёс зүйг мэдэхээ байж, ардынхаа хэлэлцдэг хэлнээс хөндийрөн холдоод харь хэлний өгүүлбэрийн зүй, монгол хэлэнд огт нийцдэггүй үг найруулгыг хар хүчээр тулгаж хэрэглэдэг нь унших хүнд утга буруудуулан, санаа бүрхэгдүүлэх үзэгдэл үргэлжилсээр” (Ринчен. 1956,60) хэмээн шүүмжилсэн. Монгол хэлний зүйг бодолгүй, өөр хэлний өгүүлбэр бүтэх ёсыг нарийн учры нь ухамсарлан бодолгүй хэрэглэсэн байдал үзэгддэг. Жишээ нь: “Дуурь бүжгийн улсын театр” гэж хачин бүтэц, найруулга бүхий нэр хаяг буй болсныг академич Б. Ринчен “монгол өгүүлбэр бүтэхзүйн үүднээс үзвэл “дуурь бүжгийн улс” гэж нэг улс байдаг” (Ринчен. 1971. №79) гэж ойлгогдохоор болсон явдлыг шүүмжилсэн байна.

Судалгааны явцад тааралдсан сонирхолтой зүйлийн нэг бол профессор Д.Цэнд “Зохиолчийн бичгийн хэлний боловсрол” нийтлэлдээ ардын ярианы хэл тунгаагдаагүй түүхий хүдрийн байдалтай бол бичгийн хэл нь энэ хүдрийг



тунгаан цэвэрлэж, аль шилдэг содон зүйлсийг шингээсэн байдгийг манай ахмад зохиолч Ц. Дамдинсүрэн /1908-1986/, Д.Нацагдорж /1906-1937/, Б.Ринчен /1905-1977/ нарын зохиол бүтээлээр жишээ авч тайлбарлажээ. Тэрээр энд бичгийн хэл соёлын тансаг, нандин давуу талыг харуулахаа урьтал болгоод, аман соёл, ярианы соёлын утга санааг илэрхийлэх өргөн боломж, амьдлаг шинж, давуу тал, онцлогийг орхигдуулсан тал ажиглагдаж байна. Тэрээр “ярианы хэл тунгаагдаагүй түүхий хүдрийн байдалтай” гэсэн зүйрлэлээрээ ярианы соёлыг бичгийн соёлоос доогуур тавьж, илтэд дутуу үнэлсэн байдал ажиглагдаж байна.

1960-аад оны эхээр монгол хэл ярианы соёл, ялангуяа зөв дуудлагын хэм хэмжээний талаар хэл бичгийн ухааны доктор Э.Вандуй “Үгийн боловсролоо нэмэгдүүлж, зөв боловсон ярихын төлөө” /1960. 23/, “Монголын утга зохиолын хэлний дуудлагын нормын асуудал”/1962. 56-62/, “Орчин үеийн монголын утга зохиолын хэлний нормын асуудалд” /1964.№16/, “Монгол хэлний зөв дуудах ёсны зарим асуудлаас”/1966/ зэрэг эрдэм шинжилгээний өгүүллүүдийг бичиж, “сул үгийг аль болохоор хэрэглэхгүй байхыг хичээх”(Вандуй. 1960,16)-ийг чухалчлан сануулжээ.

Монгол хэл, ярианы соёлын талаарх судалгааг он удаан жил үр бүтээлтэй хийсэн эрдэмтний нэг нь Ш.Барайшир багшийг гэж үздэг. 1950-иад оны эцсээс түүний эхлэн хийсэн судалгаанд эх хэлний боловсролын тухай асуудал чухлаар тавигдаж байв. “Элдэв юмс, үзэгдэл хийгээд тэдгээрийн харилцан холбоо зэргийг илтгэн үзүүлэх хэл ярианы хэм хэмжээг жинхэнэ ёсоор ухааран ойлгож, зөв чадамгай хэрэглэхэд”(Барайшир. 1971.№209) ярианы соёл, үгийн боловсролын мөн чанар оршино гэж үзжээ. Д.Отгонсүрэн “Уран зохиолын хэлний тухай”/1974/, “Ярианы найруулга, соёл”/1979/ зэрэг судалгааны ном хэвлүүлж олны хүртээл болгожээ. Тэрээр “Ярианы найруулга, соёл” бүтээлдээ ярианы найруулгыг утга зохиолын хэлний нэгэн төрөл болох талаас судалж, ярианы хэлийг ангилан, ярианы хэл, бичгийн хэлний харилцан хамаарлыг авч үзээд, ярианы соёлд харшлах болон нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулсан байна.

Бүх нийтийн хэл ярианы соёлыг дээшлүүлэх чухал шаардлагын үүднээс “Утга зохиол, урлаг” сонины газар 1980 онд “Ярианы соёлыг дээшлүүлэх тухай” сэдвээр ярилцлага явуулжээ. Энэ ярилцлагыг судлаач Н.Жамбалсүрэнгийн бичсэн “Үг хэлний соёлыг дээшлүүлэх асуудалд” хэмээх асуудал дэвшүүлсэн өгүүллээр эхэлж, эл ярилцлагад профессор П.Хорлоо, дэд эрдэмтэн Ш.Барайшир, Ц.Өнөрбаян, багш Д.Бадамдорж, Ч.Батсүрэн, эрдэм шинжилгээний ажилтан Я.Цэвэл нарын арваад хүн оролцож, шинэлэг санаа дэвшүүлсэн өгүүллүүд нийтлүүлжээ. Эдгээр өгүүллэд “хүн бүр үг хэлнийхээ соёлыг дээшлүүлэхийн тулд эх хэлнийхээ дотоод зүй тогтол, түүний баялаг чанар, хэл найруулгын тогтсон хэм хэмжээг сайн мэдэж, түүндээ захируулан яриа бичгийн өндөр соёл эзэмшихийн чухлыг онолын үүднээс дүгнэн бичжээ”(Өнөрбаян.1980. №50). Мөн үндэсний хэлний хамгийн боловсронгуй хэлбэр болсон утга зохиолын хэм хэмжээ, түүнд тавих нэгдмэл шаардлагыг онол, практикийн талаас нь дэлгэрэнгүй тайлбарлаж, хэлний практикт элбэг тохиолдож буй дутагдлыг баримтаар шүүмжлэн, тэдгээрийг засах арга замын талаар өөр өөрийн саналыг дэвшүүлсэн байна. Хүмүүсийн өдөр тутмын хэлний боловсролд байнга нөлөөлж, түүнийг дээшлүүлэхэд идэвхитэй үүрэг гүйцэтгэдэг хүчирхэг хөшүүрэг нь ном, сонин, сэтгүүл, радио, телевиз, театрын хэл яриа билээ. Энэ чиглэлээр монгол хэлний найруулга зүй судлаач Ц.Сүхбаатар олон өгүүлэл хэвлүүлсэн байна. 1986 онд “Утга зохиол, урлаг” сонины газраас “Хэл ярианы соёл” хэмээх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулжээ.

Энэ хэлэлцүүлэгт хэл бичгийн ухааны доктор Д.Дашдаваа, Ц.Сүхбаатар нар “Буруу ярьж, зөв ойлгодог гэдэг үнэн үү?”, “Гэртээ байгаа юм чинь”, багш Ж.Лувсандорж “Хүүхдийн хэл”, доктор Э.Пүрэвжав “Мэндлэхээсээ эхэлж” зэрэг өгүүлэл бичиж оролцож, хэл ярианы соёлын тулгамдсан асуудлуудыг олон талаас нь хөндөж хэлэлцүүлсэн байна.

Профессор Чой.Лувсанжав “Эх хэл юүгээн эрхэмлэе”/1988.№179/ өгүүлэлдээ “эх хэл юүгээн шинжлэхүй ухааны монгол хэл, олон нарийн мэргэжлийн монгол хэл, албан бичгийн монгол хэл найруулга, шинэ монгол нэртөмьёо, ярианы зөв найруулга зэргийг ирмүүн журамлан цэгцлэх цаг хэдийнэ болжээ”(Лувсанжав.1988.№179) гэж дүгнээд “монгол мэндчилгээний үг хэллэг, талархлын үг, хүндэтгэлийн үг, цээрлэл, эерүүлэх үг хэллэгийн талаар өгүүлсэн нь монгол уламжлалт ардын зан үйлтэй нягт холбоотой үг хэллэгийг сурч эзэмшихэд өгөөжтэй зүйл болжээ.

Профессор С.Галсан өнөөгийн монгол хэлний байдал, ярианы онцлогийг судалж, “хэл судлаачид бол хэлэнд хууль ёс тогтоогчид байх учиргүй. Харин хэлний дотоодод нь байгаа зүйлийг илрүүлэн судлагчид”(Галсан. 1991.№29) гэсэн дүгнэлт гаргасны зэрэгцээгээр хэл судлаачид хэлний хэрэглээний соёлыг хөндлөнгөөс ажиглагч, идэвхигүй байр сууринаас хандагч биш, хэлний хэрэглээний соёлыг чиглүүлэн залагч нар, хэлэнд ухамсартай хандах явдлыг биечлэн үзүүлэгчид баймаар байна гэж онцлон тэмдэглэсэн байна.

Э.Пүрэвжав “Монгол хэл ярианы соёлын зарим асуудал”/1993/ диссертаци болон “Монгол хэлний хэм хэмжээ” /1996/, “Монгол мэндчилгээ” /1995/ зэрэг бүтээлүүддээ монгол хэл ярианы соёлыг хэлний хэм хэмжээний онолын үүднээс монгол хэлний дуудлагын хэм хэмжээ, монгол хэлний үг хэрэглээний хэм хэмжээ, монгол хэлний хэл зүйн хэм хэмжээ гэсэн үндсэн асуудлуудын хүрээнд судалж, “хэл ярианы соёлын судалгаа хэл шинжлэлийн хүрээнээс хальж нийгэм, соёл, түүхийн учир холбогдолтой болсоор байна” (Пүрэвжав. 1996.73-74) гэж цохон тэмдэглэжээ. Үүний гэрч болж сүүлийн үед Ж.Долгорсүрэн “Аман соёлын арга билгийн шүтэлцээ”/2000/, Ж.Баянсан “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ” (2002), “Тайз дэлгэцийн ярих урлаг”/СУИС. 2004/ зэрэг соёл, урлаг судлалын ном бүтээлүүд хэвлэгдсэн юм. Энэ нь ярианы соёлыг зөвхөн хэл шинжлэлийн онол, аргазүйгээр, үг шинжлэх ухааны хүрээнд судалж ирсэн уламжлалыг өргөжүүлэн тэлж, хэл соёлын асуудлыг соёл судлал, соёлын хүн судлал, урлаг судлал, хэлний соёл судлалын үүднээс судлах судлаачдын танин мэдэхүйн эрэлт хэрэгцээ буй болсоныг харуулж байна. Орчин үед хүн ба соёлыг үзэх үзэл онолын хандлага өөрчлөгдөж, хүн ба соёлын мөн чанарын тухай асуудлыг чухам ямар онол арга зүйн үүднээс, хэрхэн яаж судлан шийдвэрлэхтэй холбоотойгоор дээрх танин мэдэхүйн асуудал дэвшигдэж байна.

Ингэж ярианы соёлын тухай асуудлыг дагнан судалсан шинжилгээ судалгааны ажил сүүлийн 70 гаруй жилд идэвхтэй хөгжиж ирсэн бөгөөд цаашид шинжлэх ухааны орчин үеийн шинэ шинэ аргазүйгээр баяжин хүрээ хязгээрээ тэлж хөгжих хандлага ажиглагдаж байна.

2. Ярианы соёлын хэм хэмжээт чанар

Аливаа соёлын бусдаас ялгарах гол онцлог нь түүний эрэмбэлэг /иерархичность/, хэм хэмжээт шинж чанарт байдаг. Соёлын аливаа үзэгдэл өөрийн дотоод эрэмбэлэг хэм хэмээт шинжээ алдвал тэр соёл оршин тогтнох үндсээ



алддаг. Иймээс ярианы соёлын оршин тогтнох гол үндсийг нэг талаас үндэсний соёл сэтгэлгээ, үнэлэмжийн дотоод эрэмбэлэг шинж чанар., нөгөө талаас хэл соёлын хэм хэмээнд захируулан түүнийг илэрхийлэх үр ухаан, хэлэх, ярих үйлийн амьд чадвар гэж үзэж болно.

Үгэнд учир, суманд занги бий гэж өвөг дээдсийн маань сургасан сургаал үг гүн гүнзгий утгатай бөгөөд хэлэх, ярих нь хэм хэмжээт үзэгдэл болохыг сануулсан хэрэг. Хэлж ярьсан үг бүхэн нь өгүүлэгчийнхээ шинж чанар, үнэлэмжийг гойд илэрхийлж байхын сацуу, нийгмийн хэм хэмжээг давхар илтгэдэг онцлогтой. Ямар үг сонгож хэрэглэх нь нэг талаас хэлний хэм хэмжээний асуудал байх боловч нөгөө талаасаа энэ нь ард түмний ёс заншил, зан үйлийн бичигдээгүй хуулийн хэм хэмжээгээр хязгаарлагдан зохицуулагдаж байдаг бас нэгэн онцлогтой юм. "Хэмжээнээс хэтэрсэн бүхэн хэв төрхөө алддаг. Чухам энэ тохиолдолд хэлж ярьсан үг хэллэг нь тоон хэмжигдэхүүнээр бус нийгмийн хэв ёсоор хэмжигдэхэд хүрдэг. Монголчуудын жигшин цээрлэдэг "арван хар нүгэл"-ийн "хов үг", "чалчаа үг", "худал үг", "ширүүн үг" зэрэг нь хэлээр үйлдэх дөрвөн нүгэлд ордог" (Пүрэвжав.1993. 27) бөгөөд энэ нь монголчуудын юуг сайн, юуг муу, муухай зүйл гэж үздэг үнэлэмжийг тод илтгэж байна. Монголчууд хэзээнээс нааш хараал, зүхэл хэлэхийг ихэд цээрлэж, уурлаж уцаарласан үедээ хараалын оронд "буянаа нэм", "тосоор гоож", "заяа нь дэлгэр", "зуу насал" гэх зэрэг гүн гүнзгий бэлгэдэл бүхий ерөөлийн үг хэллэгээр зөрүүлэн хэрэглэж заншсан аман соёлын баялаг уламжлалтай ард түмэн. Энэ нь ярианы соёл хэлний хэм хэмжээ, нийгэм-ёс суртахууны хэм хэмжээнд тулгуурлан хөгжих зүй тогтолтой болохыг илтгэж байдаг. "Бодот байдал, хэл хоёрын харьцаанд түшиглэн хэлний хэм хэмжээ оршин тогтнох" (Базаррагчаа. 1984. а. 29) бөгөөд үүнд нийгмийн үнэлэмж ихээхэн нөлөөтэй аж. Нийгмийн хөгжлийн гажуудал, доройтол бүхэн хэл ярианы соёлын хэм хэмжээг алдагдуулж иржээ. 1980, 1990-ээд оны үед төвийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонин сэтгүүлд монгол хэл ярианы соёлын тухай сэдвээр удаа дараа хэлэлцүүлэг явуулж, монгол утга зохиолын хэлний хэм хэмжээний гажуудал, аман болон бичгийн хэлний буруу ташаа байдал, эх хэл соёлдоо зүй зохисгүй хандах явдлыг тухай бүр нь шүүмжилж, засч залруулах талаар эрдэмтэн мэргэд үгээ хэлж, ажил хэрэгч хандаж байсан. Тэр үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байсан хэлэлцүүлгүүд нийгэм, олон түмний анхаарлыг эх хэлний боловсрол, ярианы соёлд хандуулснаараа ихэд ач холбогдолтой байв. Монгол оронд ардчилал гүнзгийрч, плюрализм газар авч, орчин үеийн техникжсэн нийтийн соёл түрж, мэдээлэл хүчтэй болохын хэрээр эх хэлний боловсрол доройтож, ярианы соёл нийгэмд гүйцэтгэх үүргээ биелүүлж чадахгүй болж ирсэн нь түүний хэм хэмжээт чанарын доройтолыг илтгэх болов. Шинжлэх ухаан, техник, нийгмийн хөгжлийн хурдцыг дагаад сэтгэхүй хөгжиж, түүнийг илэрхийлэх хэрэгцээг дагаж монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн байнга өөрчлөгдөн баяжиж байгаа өнөө үед гадаад хэлнээс гаралтай нэртомьёог монгол хэлэнд тэр чигээр нь орчуулахгүй хэрэглэх, эсвэл гадаад үг нэг бүрийг монголчлон орчуулах гээд байдаг хоёр төрлийн хэт туйлшрал бий болоод байна. Энэ нь зарим нэг харийн хэл соёлд ихэд татагдан орсон цөөн хүний үнэлэмжийн хувьсал өөрчлөлтийг илтгэж байгаа бөгөөд мөн л нийгмийн учир шалтгаантай юм. Социализмын үед ярианы хэлэнд орос хэлний статус өндөр байх үед орос үг хэллэг их хэмээжээгээр хэрэглэдэг байсан. Тэгвэл орчин үед дэлхий дахинд англи хэлний статус өсөхийн хэрээр англи үг хэллэгийг залуучууд гол төлөв их хэмээжээгээр хэрэглэх болсон нь тод анзаарагдаж байна. Энэ нь эх хэл соёлтой харийн

хэл соёл эн чацуу зэрэгцэн орших болсныг илтгэж байна. Гэхдээ соёл хоорондын харилцаа идэвхижиж буй өнөөгийн нийгэмд үндэсний хэл соёл, харийн хэл соёлын хэрэглээний зохист хэм хэмжээг олж зөв сонголт хийх нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Ялангуяа монголын үндэсний соёлын орон зайд нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, аялал жуулчлалын олон талт шалтгаанаар харийн соёл хүчтэй түрэн орж ирэхийн хэрээр ярианы соёлын хэм хэмжээт чанар улам бүр гээгдэж байна. Монгол хүмүүс хоорондоо утга төгөлдөр, аялага сонсголонтой, яруу сайхан монгол хэлээрээ ярих нь монголын нийгэм, монгол үндэстэн оршин тогтнох гол үндсийг бүрдүүлэх ач холбогдолтой билээ. "Хэлний боловсрол бол зайлшгүй нийт ардын боловсрол, утга зохиолын хөгжилтэй холбогдолтой бөгөөд шинжлэх ухаан техник, улс ардын байдалд нэвтрэн буй лугаа зайлшгүй холбогдолтой учраас сэхээтэй ухамсартай хүн, хувцас хунараа цэвэр боловсон авч явах лугаа адил, бусадтай бичгээр буюу амаар харилцахдаа мөн цэвэр, боловсон хэлээр санаагаа илэрхийлэхийг хичээх нь орчин үеийн хөгжлийн шаардлага болж байна" (Ринчен. 1969) гэсэн их эрдэмтний хэлсэн үг өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй хэвээр байна. Иймд ярианы соёлын суурь хэм хэмжээ болох хэлний хэм хэмжээнд захируулан түүнийг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор дэвшигдэж байна.

Аль ч ард түмэн, үндэстэн ястны хэлэнд хэлний хэм хэмжээ (norm of language., языковая норма) гэж байдаг. Хэлний хэм хэмжээт чанар бол аман соёлын, тэр дундаа ярианы соёлын тулгуур ойлголт, үндсэн судлагдахуун мөн. Ерөөс ярианы соёлын үүсэн хөгжих, оршин тогтнох амин сүнс нь хэлний хэм хэмжээнд захирагдах явдал байсаар ирсэн. "Хэлний хэм хэмжээ" хэмээх нэртомьёог хэл шинжлэлд *нэгдүгээрт*, хүмүүсийн хэл ярианд олонтаа давтагдаж байдаг нийтээрээ мэдэх хэрэглээ буюу (далд ухамсрын түвшинд хүрч мөрдлөг болсон хэм хэмжээ. Ж.Д.), *хоёрдугаарт*, сурах бичиг, толь бичиг, лавлах тэргүүтэнд тэмдэглэн тайлбарласан хэлний хэрэглээний заавар, дүрэм журам" (Ицкович, 1982, 7) буюу (ухамсрын түвшинд хэрэглэх хэм хэмжээ. Ж.Д) гэсэн хоёр талтай юм. Хэлний хэм хэмжээ тухайн үндэсний хэл соёлын бүтэц бүрэлдэхүүний онцлог, нийгэм, түүхийн уламжлалтай нарийн нягт холбоотой бүрэлдэн төлөвшсөн байна. Иймээс хэлний хэм хэмжээг нийгэм хам олноороо хүлээн зөвшөөрсөн харьцангуй тогтвортой хэрнээ хөдөлгөөнт шинжтэй хэлний дүрэм журам, хэлэхүй өгүүлэхүйн үйл ажиллагааны бодот байдал, үндэсний хэлний тогтолцоо, түүний хөгжлийн зүй тогтлыг нягт тусгасан хэлэх ярих үйлийн дүрэм журам, дэг жаяг гэж үзэж болно. Өвөр монголын хэл шинжлэлтэн Ө.Наранбат хэлний хэм хэмжээг "тухайн найруулгын орчин тойронд үг өгүүлбэрийн зэрэг хэлний нэгжийг зэргэцлийн харьцаатайгаар байрлуулан хэрэглэж хэлийг яруу сайхан болгох аргыг хэлний хэм хэмжээ" (Наранбат. 1986. 94) гэж тодорхойлжээ.

Судлаачид утга зохиолын хэлний үндсэн шинж чанарыг ярианы соёлын хэм хэмжээ болдог гэж үздэг. Үүнийг бас арай өөр өнцгөөс харж болно. Соёлыг хүмүүнчлэн үзэхүйн арга зарчмын үүднээс авч үзвэл, аливаа үндэстний соёлын хэв шинжийг бүрэлдүүлэгч дотоод суурь хүчин зүйл болох сэтгэх хэв загвар, соёл сэтгэлгээ (менталитет), тухайн соёлын дотоод хэм хэмжээт чанар буюу үнэлэмж нь хэлний хэм хэмжээг үүсгэх дотоод гол эх сурвалж болох учиртай. Утга зохиолын хэлний хэм хэмжээний хувьд энэ нь аман соёл, ярианы соёлд баримтлах нэгэн төрлийн жишиг хэм хэмжээ байх нь зүйн хэрэг болно. Гэхдээ зөвхөн утга зохиолын хэлний хэм хэмжээ л ярианы соёлын хэм хэмжээг дангаар бүрдүүлнэ гэвэл хэт албадмал, уг соёлын гарвал



зүй, төрөлх эх сурвалжаас холдож хөндийрсөн зүйл болж болзошгүй. Утга зохиолын хэл бол тухайн нийгэм, түүхийн үйл явцыг тэргүүлэгч цөөнхийн уран сайхны сэтгэлгээ, гоо сайхны таашаал мэдрэмж, авьяас чадварын үр дүн болон онгод авьяасаар хөлөглөн бүтээгддэг зүйл. Өдөр тутмын энгийн харилцааны хэл ярианд утга зохиолын хэлний хэм хэмжээ нэг бүрийг дагаж мөрдөхийг номлох нь амьдрал практикаар дагаж хэрэгжүүлэхэд төвөгтэй төдийгүй, уг соёлын гарвалзүйн үүднээс авч үзвэл боломжгүй зүйл. Хүн тухайн нөхцөл байдлаас үүдээд янз бүрээр ярьж хэлэх тохиолдлууд байдаг бөгөөд энэ нь цаанаа хүн зүй, нийгэм зүй, сэтгэл зүйн маш нарийн үндэстэй юм. Иймд ярианы соёлын хэм хэмжээт чанар өөрөө хүний далд ухамсрын үйл ажиллагааны гүн гүнзгий угшилтай учир тухайн хүнийхээ мөн чанарыг илтгэдэг онцлогтой. Түүнээс биш ямар нэг хэвшмэл зүйлийг даган баримтлахын нэр огт биш. Яриа үүсэхдээ яригч хүмүүнийхээ дотоод хэм хэмжээний илрэл болж бүтээгддэг бөгөөд хүн өөрийн оршихуйг хангах, өөрийн мөн чанарыг хэрэгжүүлэх үүднээс ярианы соёлд зайлшгүй чанд мөрдөх хэм хэмжээ гэж бас бий. Үүний нэг нь ярианы соёлын дуудлагын хэм хэмжээ юм. Монгол хэлний дуудлагын хэм хэмжээг журамлаж нэгэн мөр болгох гэсэн оролдлогыг монголчууд эртнээс нааш хийж ирсэн байна. Монгол хэлний дуудлагыг Хөх хотын түмэд С. Галсан /1800-1870/ "Монгол үсгийн бүгд тайлбар толь"/1835/, ХХ зууны эхэн үед ард Тоогүй "Зүрхний толт хэмээх судар", академич Ш.Лувсанвандан /1910-1983/ "Монгол үгийн өргөлтийн тухай асуудалд" /1980/, М.Базаррагчаа "Зөв дуудах зүй" /1984/, Чой. Лувсанжав /1989/ "Монгол хэлний журамламал дуудлагын тухай", Э.Пүрэвжав "Монгол хэлний хэм хэмжээ"/1996/ зэрэг бүтээлүүдээрээ судалж үнэлэлт дүгнэлт өгчээ. Дээрх судлаачид үгийн алдаа модагтай дуудлага нь мэдээллийг буруу зөрүү дамжуулан ойлгуулах төдийгүй үндэсний хэл соёлын хөгжлийг гажуудуулах сөрөг талтайг анхааруулж зөв дуудлагын ач холбогдлыг чухалчилжээ. Үгийг зөв дуудахад анхаарах зүйлийн нэг бол харь гаралтай үгийн дуудлага бөгөөд харь гаралтай үг монголжих ерөнхий зүй тогтол нь монгол утга зохиолын хэлний дуудлагын хэм хэмжээнд захирагдах явдал гэж үздэг. Харь гаралтай үг эх хэлнийхээ дуудлагаас ямар нэг хэмжээгээр өөрчлөгддөг ч "эх хэлнийхээ авианы дуудлагыг хадгалдаг" (Блумфилд. 1968. 492) нь үндэсний хэл ярианы соёлын өгүүлэхүйн үйл ажиллагаа /хэлэх, ярих үйл/-ны онцлог харьцангуй тогтвортой хадгалагдах чанарыг илтгэж байна. Харь хэлний үг монгол хэлэнд аман болон бичгийн үндсэн хоёр замаар орж ирсэн байх бөгөөд чухам ямар арга замаар монгол хэлэнд нэвтрэн орж ирснээс хамарч хэлний практикт дуудлага нь янз бүр хэвшдэг явдал ч мөн хэлэх, ярих үйлийн язгуур онцлогийг илтгэдэг. Аман ярианы хэлбэрээр дамжин орж ирсэн харь гаралтай үгс монгол хэлний авиан зүйн онцлогийг даган нэлээд өөрчлөгддөг. Энэ нь ярианы соёлын харьцангуй хувьсамтгай чанарыг илтгэж байна. Монгол хүний өгүүлэх эрхтний үйл ажиллагаанд дадал хэвшил болж тогтоогүй харь хэлний үгийн зарим авиаг үг зээлдэх явцаа монгол хэлний ойролцоо авиагаар орлуулан дууддаг онцлогтой бөгөөд нэг төрөл хэлнээс нөгөөд үг орох явдал нь соёлын үзэгдлийн түгэн дэлгэрэх, харилцан нэвтрэлцэх хөгжлийн түгээмэл зүй тогтлыг илтгэдэг.

Гадаад хэлнээс гаралтай үгийг зөв дуудаж ярихын зэрэгцээгээр, гадаад хэлний нийгэмд гүйцэтгэх үүрэг өндөрсөхийн хэрээр гадаад үг хэллэгийг монгол хэлэнд хэрхэн авч хэрэглэх, яаж зөв дуудах тухай асуудал улам бүр чухлаар тавигдах болов.

Аливаа үгийн гол шинж нь тогтсон утгатай, хэвшмэл

дуудлагатай байдаг оршино. Иймд үгийг оновчтой хэрэглэж, үгийн утга, өнгө аясыг тохируулна гэдэг бол тухайн үгийн утгыг гарцаагүй байх тийм шинж чанараар нь сонгохыг хэлдэг. Хүмүүний сэтгэл оюуны дотоод ертөнцөд үүсч бүрэлдсэн баялаг утга санааг тодорхой илэрхийлэхэд үгийг оновчтой сонгох явдал хамгийн чухал. Энэ тухай академич Ц. Дамдинсүрэн /1908-1986/ "олон түмний мэддэг үгс нь далай мэт өргөн бөгөөтөл нэгэнт бичиж дадсан хэмээх хэдхэн улигт үгээр хамаг утга бүхнийг багтаан бичихийг оролдох муу заншлын үлгэр нь, зуун адуутай хүн нэг хоёр номхон морио үргэлж унаж, бусдыг ямагт салхи эдлүүлэн зэрлэг танхай явуулах мэт буюу. Иймийн тул, бичиг зохиолд аль болохоор элбэг баян үгийг хэрэглэж, оновчтой мэргэнээр найруулж, уншихад урамтай, ухахад мэдэмжтэй болгохыг хичээвэл зохино" (Дамдинсүрэн. 1934. 19) гэж сургасаныг ярианы соёлд ч мөн адил санаж, монгол хэлнийхээ баялаг үгсийн санг эзэмшин, утга төгөлдөр, уран яруу, ойлгомжтой сайхан ярихын үндэс бол үг хэрэглээний хэм хэмжээг сахих явдал юм.

Ярианы соёлын хэм хэмжээт чанар алдагдах нэг шалгаан бол харь хэлний үг хэллэгийг оновчгүй хэрэглэх явдал билээ. Нийгэм, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл урлаг, боловсрол, бизнес, шашин шүтлэгийн орон зай өргөжин тэлэхийн хэрээр гадаад хэлний үг хэллэг үндэсний хэл соёлд хүссэн хүсээгүй нэвтэрдэг нь соёл хоорондын харилцаа, соёлын солилцооны түгээмэл хууль юм. Үүнийг хэл шинжлэлд үг зээлдэх ёс гэдэг. Орчин цагийн "шинжлэх ухааны хэл бүрэлдэн тогтоход үг зээлдэх ёс онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн" (Бертагаев.1974.328) бөгөөд энэ нь үндэсний хэл соёлд байхгүй шинэ шинэ ойголто мэдээллийг тээн оруулж ирснээр хэл соёлыг баяжуулсан давуу талтай байдаг. Харин үндэсний хэлэнд байгаа нэртөмьёо, үг хэллэгийг харийн үг хэллэгээр орлуулан хэрэглэх нь үндэсний хэл соёлыг будлиантуулан бохирдуулдаг сул талтай учир ярианы соёлын хэм хэмжээг алдагдуулдаг. "Монгол хэлний үгийн сангийн нийт бүрэлдэхүүний барагцаалбал арав орчим хувь нь харь хэлнээс гаралтай үг байна" (Пүрэвжав.1986.46) гэсэн тооцоо хурдтай даяаршиж, мэдээлэлжиж буй өнөө үед лавтайга хэд дахин өссөн байх магадлалтай юм. Сүүлийн үед монголчууд яриандаа орос, англи цөөн тохиолдолд солонгос, япон үг хэллэгийг нилээд хэрэглэх болсон нь ажиглагдаж байна. Монгол хэлээ дорд үзэж, харь хэлийг шүтэгчдийг бүүр В. Инжаннашийн үед/1873-1892/ "манай газрын хянамгай үгүй ард өөрөө өөрийн монгол хэл ба үсгээ туйлд хүртэл хичээн хянах үгүй бөгөөд нэг хоёр иргэн /хятад/ үсэг таниваас даруй монгол үсгээ басамжлан монгол үгсээр иргэний санааг бүртгэн гаргаж хэрхэн чадмой хэмээн амны аяар чалчмой. Тэр маш ихэд ташаарсан хэрэг болой" (Инжаннаши. 1957. 15) гэж шүүмжилж байсан бөгөөд үүнийг одоо ч бид ярианы соёлын практикт санаж явах ёстой зүйлийн нэг мөн. Монгол хэл соёлоо дээдэлдэг зарим хүмүүс хэдийгээр гадаад хэл сайн сурсан ч гэсэн яриандаа аль болох гадаад үг хэрэглэхгүй байхыг хичээдэг болсон сайн тал бас нилээд ажиглагдаж байна.

Аливаа хэлэнд "амьдрал үйл ажиллагааныхаа зарим нэг зүйлийг бусдаас далдлан нүүхыг эрмэлзсэн хүмүүсийн зорилгоос үүдэж этгээд үг хэллэг үүсдэг" (Головин.1988.111) бөгөөд энэ нь ярианы соёлын хэм хэмжээ зөрчигдөх бас нэгэн шалтгаан болдог. Үг хэллэгийн үндсэн утгыг албаар гуйвуулж далд нууцлаг санаа оруулж, ярианы соёлын хэм хэмжээнээс ялгавартай зохиомлоор бий болгосон үг хэллэгийг этгээд үг хэллэг гэдэг. Энэ нь нийгмийн байдал, ажил мэргэжил, ашиг сонирхолын хувьд адил төсөөтэй талуудаараа холбоотой тодорхой хэсэг бүлгийн ярианд голчлон хэрэглэгддэг



бөгөөд энэ нь зарим талаараа субкультур (лат. Sub-под)-ын шинжтэй юм. Этгээд үг хэллэгийг “гадаад орчноос тусгаарласан онцгой үг хэллэг” (Балли. 1961.278) гэж үздэг. Бүтцийн хувьд “этгээд үг хэллэгийг *нэгдүгээрт*, энгийн үгийн үндсэн утгыг шилжүүлэн өөр утгаар хэрэглэсэн үг хэллэг, *хоёрдугаарт*, үгийг товчлон хурааж, тонгоруулж хэлсэн буюу дуудлагыг нь зориудаар гуйвуулсан хэллэг” (Пүрэвжав. 1993.73) гэж хоёр хэсэгт хуваадаг. Орчин цагийн монгол хэлэнд гадаад хэлнээс үүсэл гаралтай этгээд үг хэллэг бас байна. Тухайлбал, “Халтуур, халтуурдах гэсэн ажил үйлийг чанар муутай хариуцлагагүй хийж гүйцэтгэхийг заасан үг нь “олон улсын чанартай этгээд үг хэллэг” (Скворцов. 1980. 170)-т тооцогддог юм байна. Чамирхахыг рекламдах, худлаа хэлж хуурахыг панаалдах, гол гаргах, дэмий ярих чалчихыг буу халах, замын зардлаа төлөхгүй унаагаар зорчихыг туулайчлах, хүнийг үл тоомсорлож дорд үзэхийг мэке амьтан, ерваа амьтан гэх мэтээр ярьдаг таагүй хандлага байгааг мөн үг хэрэглээний хэм хэмжээг зөрчсөн байдал гэж үздэг.

Үг гажвал, утга эвдэрдэг учир ярианд хэлзүйн хэм хэмжээг чанд баримтлах нь аман ярианы соёлын чухал шалгуур мөн. Үүнийг хэл шинжлэлд хэлзүйн гүн ухаан судалдаг байна. Ярианы соёлын төвшин нь ярьж байгаа хүний хэлэх гэсэн санаагаа илэрхийлж гаргах аргаас хамаарч өөр өөр байдаг. Ярихдаа ямар аргыг хэрхэн зөв сонгож авахаас их зүйл хамаардаг. Бодол санаагаа хэлзүйн хувьд зөв илэрхийлэн гаргах тэр хувилбарыг л сонгох хэрэгтэй болдог. Энэ нь үг хэллэгийг зөв сонгож байрлуулах явдал юм. Ойролцоо утгатай олон үг хэллэгээс тухайн орчин нөхцөлд аль оновчтойг сонгох нь аман ярианы соёлын гол чухал шаардлага байдаг. Академич Б.Ринчен /1905-1977/ судалгаандаа “Үг, өгүүлбэр найруулах монгол хэлний ёсонд “хэний юуны юу вэ?” гэдэг өгүүлбэрийн зүйлд үгийн дэс дараа нь утгын холбогдолтой учир, тэр дэс дарааг соливол утга солигдон өөрчлөгддөг өгүүлбэр зүйн ёс /хэл зүйн хэм хэмжээ/ монгол хэлэнд байдаг” (Ринчен. 1971, №79) гэж бичиж байв.

Лхарамба Агваандандар /1758-1838/-ын бичсэн “Үсгийн номлол мэргэдийн амны чимэг” бүтээлд: Зохиох туурвихуйд сайн боловч, бичих сүрц муу аваас Зориг хүчит их баатар боловч, гар мухар мэт Бичих зохиохуйд үг үсгийг ёсоор эс найруулбаас Билгүүн сайн эрдэмтэн авч сонжуурлагдахын гэмт Үг, үсэг алдаагүй ч, яруу хэллэг төгөлдөр бус аваас Үзэсгэлэнт эхнэр чармай нүцгэн гүйсэн мэт” (Хүрэлбаатар. 1992.8) гэжээ. Энэ бүхэн бол хэлж ярьж, туурвин зохиоход олон зүйл сахих хэм хэмжээ байдгийг номлон сануулсан хэрэг бөгөөд үүнийг хойч үеийнхэн ямагт санаж, сахиж явууштай юм.

Ярианы соёлыг төгөлдөржүүлэх гол хүчин зүйл бол нэг талаас өгүүлэгчийн соёл сэтгэлгээний онцлогийг илтгэх үнэлэмжийн хөгжил, төлөвшил, нөгөө талаас хэлний боловсрол болох хэлж ярьж буй өгүүлбэрийнхээ гишүүдийг оновчтой зөв холбон байрлуулж, яруу сайхан, утга төгөлдөр ярих явдал юм. Энэ талаар “Хэлзүйн утга нь байрлалд шүтэж, байрлал нь холбоход шүтэх тул бүтцийн утга, холбохын утга нь харилцан нягт холбоотой шүтэн барилдсан зүйл” (Лувсанвандан.1977.23) учраас өгүүлбэрийг найруулан хэлэхдээ үгийн байрлалыг сайтар тунгаан бодож, утга агуулга нь тодорхой илэрхийлэгдэхээр холбох ёстой байдаг. Энэ нь ярианы соёлын хэм хэмжээт чанарын ухамсрын талыг илтгэдэг. Хэдийгээр энэ дүрэм журмыг сайтар ойлгож мэдэж байвч өгүүлэгчээс үг асуудалд хандах хандлага, тухайн үеийн нөхцөл байдал, сэтгэлийн хөдөлгөөнөөс хамаараад ярих хэлэх нь ихээхэн өөрчлөгдөх явдал байдаг. Энэ нь ярианы соёлын хэм хэмжээт чанарын далд ухамсрын тал болно. Эд бүгдэд үндэслэн ярианы соёл өөрийн хэм хэмжээт шинж чанарынхаа гүн бүтэц дэх далд ухамсар, өнгөн бүтэц дэх ухамсарт үйлийн харилцан үйлчлэлийн бодит үр дүн болон үүсч хөгждөг гэсэн таамаглалыг дэвшүүлж байна. Эл сэдвийн судалгааны өнгөрсөн үеийн практикаас үзэхэд, ярианы соёлыг боловсронгуй болгох асуудлыг зөвхөн үг соёлын өнгөн бүтцийнх нь үүднээс авч үзэж судлан шинжилж, зөвлөн зааварлаж ирсэн нь ажиглагдаж байна. Бие-хэл-сэтгэлээр соёлыг бүтээн туурвигч хүмүүний үнэлэмжийн бодит илрэл хэрэгжил болох ярианы соёлын гүн бүтэцэд төдийлөн гүнзгий нэвтрэн судалсан зүйл энэ удаагийн судалгаанаас харагдсангүй. Ярианы соёлын тухай асуудлыг ул суурьтай судалж шийдвэрлэхийг оролдож ирсэн шинжлэх ухааны арвин баялаг туршлага нь эрдэм шинжилгээний хойч үеийнхэнд аргазүйн ихээхэн ач холбогдолтой төдийгүй энэ талаарх танин мэдэхүйн практикийг цаашид баяжуулан хөгжүүлэх үйлсэд суурь хөрс нь болох юм. Үг соёлын үзэгдлийг дээрхи туршлагад тулгуурлан соёлын хүн судлал, хэлний соёл судлал, соёл хоорондын харилцаа судлалын үүднээс соёлыг хүмүүнчлэн үзэхүйн арга зарчимд тулгуурлан судлах шаардлага зүй ёсоор дэвшигдэж байна. Учир нь ярианы соёл бүтэц зүйн хувьдаа үнэлэмжид дулдуйдсан гүн бүтэц бүхий далд ухамсарт үйл, түүнийг илэрхийлсэн өнгөн бүтэц бүхий ухамсарт үйлийн харилцан үйлчлэлийн үр дүн болох хэлэх, ярих ур чадварын цогц үйл юм. Иймд ярианы соёлыг зөвхөн хэлний дохио тэмдгийг хэрэглэх ганц талаас нь харж судалж номлох нь өрөөсгөл болно. Үүний цаана тэдгээрийг нөхцөлдүүлэгч суурь хүчин зүйл болох хүмүүний сэрэл мэдрэмжийн далд ухамсарт үйлийн үндсийг ямар нэг байдлаар судлан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгөх нь хэлэх, ярих үйлэндээ илэрч буй хүний мөн чанарыг танин барих онол, практикийн чухал ач холбогдолтой юм.

- Актуальные проблемы культуры речи. М., 1970, 404 стр
 Арутюнова Н.Д. Язык и мир человека. М., 1998
 Базаррагчаа М. Авианы найруулга, хэлний бүтэц нормтой холбогдох нь. Уб., 1984, 33-р тал
 Базаррагчаа М. Зөв дуудах зүй. Уб., 1984, 33 –р тал
 Балли Ш. Французская стилистика. -М., 1961, 394 стр
 Барайшир Ш. Хэлний мэдлэг, ярианы соёл. - “Соёл” сэтгүүл. №4. 1973, х.47-50
 Баттогтох Д. Монголчуудын аман соёлын уламжлал// “Манай Монгол” сэтгүүл, 2003, №3 (17), 59-69
 Баянсан Ж. Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ. Уб., 2002, 118-р тал
 Баярсүрэн Ц. Монгол хэлэнд орсон харь гаралтай үгийн дуудлагын тухай. “ХЗС”, XIII боть. Уб., 1979, 82-85-р тал
 Бобровников А. Грамматика монгольского языка, –Санктпетербургь,1835, 127стр
 Вандуй Э. Үгийн болвсролоо дээшлүүлж, зөв боловсон ярихын төлөө. Уб., 1960, 23.
 Вандуй Э. Монголын уран зохиолын хэлний дуудлагын нормын асуудал. “ШУА-ийн мэдээ” сэтгүүл. №2, 1962, 56-62-р тал
 Верещагин Е.М., Костомаров В.Г. Лингвострановедческая теория слова. М., 1980
 Винокур Г.О. Основы культуры речи. М., 1984, 133 стр
 Владимирцов Б.Я. Турецкие элементы в монгольском языке. - “ЗВОРАО”, том XX, вып.II-III. –СПб, 1911, стр 153-184
 Галсан С. Өөрчлөн байгуулалт ба хэл соёл. “Үнэн” сонин, №29, 1991
 Гойхман Я., Надеина Т.М. Основы речевой коммуникации. М., ИН-ФРА-М., 1998
 Головин Б.Н. Основы культуры речи. М., 1980, 334 стр
 Головин Б.Н. Как говорить правильно. М., 1988, 160 стр
 Дамдинсүрэн Ц. Хичээл билгээн гаргаж, хэл бичгээн хөгжүүлье. -“МХБСБӨ”, тэргүүн дэвтэр - Уб., 1934, 6-60-р тал
 Дамдинсүрэн Ц. Үгийн тухай хэдэн үг. - “Залуучуудын үнэн” сонин №109, 1963
 Дамдинсүрэн Ц. Үг товчлох тухай. -“Соёл, утга зохиол” сонин. №18, 1964
 Делевой человек: культура речевого общения: Пособие и словарь-справочник. М., 1997
 Долгорсүрэн Ж. Аман соёлын арга билгийн шүтэлцээ. Уб., 2000, 210-р тал
 Жамбалсүрэн Н. Үг хэлний соёл. - “Үнэн” сонин, №87, 1968
 Инжаннаши В. Хөх судар, тэргүүн дэвтэр. -Хөх хот., 1957, 728-р тал
 Ицкович В.А. Очерки синтаксической нормы. М., 1982, 200 стр
 Лебедева Н. Введение в этническую и кросс-культурную психологию. М., 1999
 Лувсанбалдан Х. Монголчуудын үсэг бичиг, үг хэллэгийн түүх гаралаас. Уб., 1986
 Лувсанжав Ч. Монгол хүний мэндлэх ёсон. -“Ухуулагч” сэтгүүл. №5, 1988. 19-22
 Лувсанжав Ч. Эх хэл юүгээн эрхэмлэе. “Үнэн” сонин, №179, 1988
 Маслова В.А. Лингвокультурология. М., АCADEMA. 2001. 265 стр
 Мир языка и межкультурная коммуникация. Материалы международной научно- практической конференции. – Барнаул., 2001
 Нямсүрэн С. Хэл, хэлэхийн учир. Ред. С.Галсан. Уб., 1974, 76 –р тал
 Ожегов С.И, Лексикология. Лексикография. Культура речи. М., 1974, 158 стр
 Отгонсүрэн Д. Ярианы найруулга, соёл. Уб., 1979, 80 х
 Основы культуры речи. Хрестоматия. М., 1984, 310 стр
 Основы теории речевой деятельности. М., 1974, 305 стр
 Пиро Дж. Символы, сигналы, шумы. М., 1967, 246 стр
 Пүрэвжав Э. Монгол хэл ярианы соёлын зарим асуудал /хэл бичгийн ухааны дэд докторын зэрэг горилсон зохиол/ Уб., 1993, 143-р тал
 Пүрэвжав Э. Монгол мэндчилгээ. Уб., 1995, 62 –р тал
 Пүрэвжав Э. Монгол хэлний хэм хэмжээ. Уб., 1996, 78 –р тал
 Рамstedт Г.И. Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора. – СПб, 1908, 66 стр
 Ринчен Б. Хэлээ хайрлан энхрийлж, үгийн боловсролыг эрхэмлэе. –“Монгол хэл бичгийн зарим асуудал”. - Уб., 1956, 39-70-р тал
 Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн боть. Удиртгал. 1966
 Ринчен Б. Үг найруулгын учир. - “Үнэн” сонин, №79, 1971
 Сампилдэндэв Х. Малчин ардын зан үйлийн уламжлал. – Уб., 1986, 190 –р тал
 Скворцов Л.И, Теоретические основы культуры речи. М., 1980, 352 стр
 Сүхбаатар Ц, Дашдаваа Д. “Буруу ярьж, зөв ойлгодог” гэж үнэн үү? “Урлаг утга зохиол” сонин, №14, 1986
 Хэл ярианы соёл, “Үнэн” сонин, №258, 1989
 Тейяр–де –Шарден. Феномен человека. М., 1987. 359 стр
 Телия В.Н. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996
 Цэвэл Я. Хэлнийхээ боловсролыг дээшлүүлье. – “Хөдөлмөр” сонин, №1, 1960
 Цэвэл Я. Хэлний боловсролыг дээшлүүлэх асуудалд нэмэрлэх нь. “Утга зохиол урлаг” сонин, №49, 1980
 Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. Уб., 1991, 171-р тал
 Шагдарсүрэн Ц. Хэний юуны ямар вэ? –“Ил товчоо” сонин, №9, 1991
 Шмельева Т. В. К проблеме национально-культурной специфики “эталона сравнения” //Этнопсихоллингвистика. - М., 1988